



**ШИНЭ ДЭД ТӨВ**

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

# **“ТОЛГОЙТ ДЭД ТӨВ”-ИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:0004103 /**

## Гарчиг

<b>ОРШИЛ</b> .....	<b>4</b>
<b>1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>5</b>
<b>2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	<b>11</b>
<b>3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	<b>100</b>
<b>4. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	<b>101</b>
<b>5. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b>	<b>102</b>
<b>6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> ..	<b>146</b>
<b>7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ</b> .....	<b>171</b>
<b>8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	<b>178</b>
<b>9. ТУХАЙ ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	<b>187</b>
<b>10. ДҮГНЭЛТ</b> .....	<b>188</b>
<b>11. ХАВСРАЛТ МАТЕРИАЛ</b> .....	<b>190</b>

**ТОВЧИЛСОН ҮГС**

АХБ - Азийн Хөгжлийн Банк

БОАЖЯ - Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам

БОМТ - Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө

БОМТБТ - Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний биелэлтийн тайлан

БОХШХ - ТДТ Байгаль Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

БОНЕУ - Байгаль Орчны Нөлөөллийн Ерөнхий Үнэлгээ

БОННУ - Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ

БОХХ - Байгаль Орчны Хөндлөнгийн Хяналт

ЕХОБ - Европын Хөрөнгө Оруулалтын Банк

ЗДХ - Зөвшөөрөгдөх Дээд Хэмжээ

БОХЗТЛ - Байгаль Орчны Хэмжилзүйн Төв Лаборатори

НЗДТГ - Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар

НБОГ - Нийслэлийн байгаль орчны газар

НӨ - Нөлөөлөлд Өртөх

ТДТ - Толгойт Дэд Төв

ГХХХОДХ - Гэр Хорооллыг Хөгжүүлэх, Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хөтөлбөр

ТУН - Төслийн Удирдах Нэгж

## **ОРШИЛ**

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичгийн дагуу хотын гэр хорооллын дэд бүтэц, нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулах, тогтвортой хөгжүүлэхэд чиглэгдсэн арван гурван жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын хөтөлбөр бөгөөд төсөл хэрэгжсэнээр агаар, хөрс, усны бохирдол буурч, тухайн нутаг дэвсгэр дэх оршин суугчдын эрүүл аюулгүй амьдрах эрх хангагдана гэж үзэж байна.

Тус хөтөлбөр нь Нийслэлийн Засаг даргын тамгын газрын санаачлагаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй хөтөлбөр бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын гэр хороололд нийт 6 дэд төвийг сонгон авч, инженерийн шугам сүлжээ, нийгмийн барилга байгууламж, нийтийн зам талбайг барьж тохижуулах ажлыг 3 үе шаттайгаар төлөвлөн хийж буй юм. Үүнд:

- ❖ Төслийн 1-р үе шат: Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд
- ❖ Төслийн 2-р үе шат: Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төвүүд ба бусад нийгмийн байгууламжууд
- ❖ Төслийн 3-р үе шат: Шархад, Толгойт дэд төвүүд тус тус хамрагдаж буй юм.

Хөтөлбөрийн үндсэн зорилт нь сонгосон дэд төвүүдэд амьдралын чанарыг дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бөгөөд дэд төвүүдийг дахин зохион байгуулах, хотын үйлчилгээг өргөтгөх; оршин суугчдын хэрэгцээ шаардлага дээр үндэслэсэн нийгэм эдийн засгийн үйлчилгээ, төвлөрлийг сайжруулах; оршин суугчдын санал дэмжлэгтэйгээр орон сууцжуулалт, дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийнхнийг оролцуулах; үйлчилгээ хүргэгч байгууллагуудын үйл ажиллагаа ба менежментийг сайжруулах; салбарын шинэчлэл, институци бүтцийг сайжруулж, чадавхийг бэхжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах зэрэг дахин төлөвлөлтийн үйл явцыг эхлүүлэх юм.


Толгойт дэд төвийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) 2023 оны 5-р сард БОАЖЯ-аар батлагдсан. Тус БОННУ-ний хамтаар 2023-2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) батлагдсан. 2023-2026 оны БОМТ болон төслүүдийн 2024 оны үйл ажиллагаатай уялдуулан 2024 оны БОМТ-г “Байгаль орчин, ногоон хөгжлийн яам”-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 дугаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

# 1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Ерөнхий мэдээлэл

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн 3-р үе шатанд хамрагдах Толгойт дэд төв нь Сүхбаатарын талбайгаас 12км, хамгийн ойр байрлах Баянхошуу дэд төвөөс 4 км зайд байршилтай. Энэхүү бүс нь баруун хэсгийн хотын алслагдсан бүс юм. Толгойт дэд төвийн газар нутагт нийт 551,4 га газар харъяалагдах ба Сонгинохайрхан дүүргийн 1, 2,3, 20, 35 дугаар хороодууд багтдаг.

Зураг 1. Дэд төв, төслийн талбайн байршил



Толгойт дэд төвийн хүрээнд хийхээр төлөвлөгдсөн дэд бүтцийг хөгжүүлэх ажлын тоо хэмжээг доорх хүснэгтэд чиглэл тус бүрээр нь хураангуйлан үзүүлэв.

**Хүснэгт 1. Төслийн хүрээнд хийгдэх ажлын тоо хэмжээ**

№	Багцын дугаар		Багцын нэр	Хийгдэх ажил
1	ТЭС	А	ТДТ-ийн мэдээлэл холбооны шугам сүлжээ	<ul style="list-style-type: none"> <li>- Холбооны худаг сувагчлал, шилэн кабель 8.1км</li> <li>- Холбооны цамхаг 25-30м</li> <li>- Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв - 2 давхар зоорьтой</li> <li>- Мэдээлэл холбооны байр - 1 давхар зоорьтой</li> </ul>
2		В	ТДТ-ийн цахилгааны хаалттай дэд өртөө ба 10кВ цахилгаан дамжуулах кабель шугам	<ul style="list-style-type: none"> <li>- Хаалттай дэд өртөө 2*630кВА</li> <li>- 10/0.4 кВ-н - 8 иж бүрдэл</li> <li>- 10кВ-ын хос кабель шугам - 8.1км</li> </ul>
3		С	ТДТ-ийн цахилгааны хуваарилах байгууламжууд ба 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам	<ul style="list-style-type: none"> <li>- ПРП дэд станцын 10кВ-ын хуваарилах байгууламжийг буулгах - 1ш</li> <li>- ПРП дэд станцын 10кВ-ын хуваарилах байгууламжийг шинээр барих - 1ш</li> <li>- "ПРП" дэд станцаас ТДТ хүртэлх 10кВ-н 4 хос кабель шугамын ажил - 13км</li> <li>- Хаалттай дэд өртөө 2*630кВА 10/0.4 кВ-н - 2 иж бүрдэл</li> <li>- 10кВ-ын хуваарилах байгууламж - 2 иж бүрдэл</li> </ul>
4	TRDN11	А	ТДТ-д хийгдэх ариутгах татуургын шугам суурилуулалтын ажил	<ul style="list-style-type: none"> <li>- Бохирын шугам хоолой /Ф100-1000мм/ - 4710м</li> <li>- Бохир усны худаг /Ф1000-2000мм/ - 77ш</li> <li>- 10/0.4кВ цахилгаан, холбооны кабель, шугам зөөж шилжүүлэх</li> <li>- Дулаан, цэвэр усны шугамыг хүчитгэх</li> <li>- А2 авто зам 2177м</li> </ul>
5		В	ТДТ-ийн авто замын ажил	<ul style="list-style-type: none"> <li>- Авто зам А4 хэсэг 633м урт авто замын ажил, А5 300м урт автозам 444м2 авто зогсоол, автобусны буудалтай</li> </ul>
6		С	ТДТ-ийн насосын станц болон усан шугам сүлжээ	<ul style="list-style-type: none"> <li>- Усан хангамжийн сүлжээ</li> <li>- Ус хангамжийн шугам хоолой ба худгууд</li> <li>- Насос станц Q=4600m3/х</li> <li>- Насос станцын иж бүрэн барилга байгууламж, гадна тохижилт, зам талбай</li> <li>- Одоо байгаа цахилгааны 10кВ, 0.4кВ-н кабель шугамыг шилжүүлэх, буулгах ба шинээр татах</li> </ul>
7	TRDN14	А	ТДТ-ийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (1-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> <li>- СХД-ийн 1, 2-р хорооны нутаг дэвсгэрийн ТДТ дэх 1.3 км урт А2 Авто замын ажил;</li> <li>- Ф100мм-Ф500мм хүртэл голчтой 1.14 км Гадна ариутгах татуургын угсралтын ажил</li> <li>- 1.5 км урт Ф100мм-Ф300мм хүртэл голчтой Гадна дулааны шугам сүлжээний ажил;</li> <li>- 966м урт Ф50мм-Ф300мм хүртэл голчтой Гадна цэвэр усны шугам угсралтын ажил;</li> <li>- Ус дулаан дамжуулах төв №2,№3,№4-ын барилга угсралтын ажил;</li> <li>- Кабель шугам, эрчим хүчний байгууламжийг хүчитгэх, шилжүүлэх, буулгах ба шинээр татах ажлууд</li> </ul>
8		В	ТДТ-ийн авто зам, дулааны сүлжээ болон бусад	<ul style="list-style-type: none"> <li>- СХД-ийн 1, 2-р хорооны нутаг дэвсгэрийн ТДТ дэх 0.473км урт А2 Авто замын ажил;</li> <li>- Ф100мм-Ф500мм хүртэл голчтой 1.14 км Гадна ариутгах татуургын угсралтын ажил</li> </ul>

**ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

			дагалдах ИШС (2-р хэсэг)	<ul style="list-style-type: none"> <li>- 2.15км урт Ф32мм-Ф350мм хүртэл голчтой Гадна дулааны шугам сүлжээний ажил;</li> <li>- 2.63км урт Ф50мм-Ф300мм хүртэл голчтой Гадна цэвэр усны шугам угсралтын ажил;</li> <li>- Ус дулаан дамжуулах төв №1 ба №5-ын барилга угсралтын ажил;</li> <li>- Кабель шугам, эрчим хүчний байгууламжийг хүчитгэх, шилжүүлэх, буулгах ба шинээр татах ажлууд</li> </ul>	
9	<b>SHTL</b>	<b>A</b>	ТДТ-ийн тохижилт, ногоон байгууламжийн ажил (байршил 1)	<ul style="list-style-type: none"> <li>- Багц 1: ТДТ дэх ногоон байгууламж бүхий тохижилттой талбай 4197.92м<sup>2</sup> явган зам, дугуйн зогсоол, явган гүүр, тоглоомын талбай, амрах хэсэг, ногоон байгууламж, талбайн гэрэлтүүлэг, камержуулалтын ажлаас бүрдэнэ.</li> <li>- Багц 2: ТДТ дэх ногоон байгууламж бүхий тохижилттой талбай 2433.64м<sup>2</sup> явган зам 497.13м<sup>2</sup>, дугуйг зам 154.09м<sup>2</sup>, тоглоомын талбай 240.83м<sup>2</sup>, авто зогсоол 149.2м<sup>2</sup>, ногоон байгууламж 358м<sup>2</sup></li> </ul>	
10			<b>B</b>	ТДТ-ийн тохижилт, ногоон байгууламжийн ажил (байршил 2)	<ul style="list-style-type: none"> <li>- Нийт - 1.45га</li> <li>- 4,119.37м<sup>2</sup> - Авто зам болон машины зогсоол</li> <li>- 7,233.36м<sup>2</sup> - Ногоон байгууламж</li> <li>- Сагсан бөмбөгийн талбай (2 шиттэй) 3x3 сагсан бөмбөгийн талбай, Гар бөмбөгийн талбай, Агаарын теннисний талбай, Хүүхдийн тоглоомын талбай, Ахмад насан болон өсвөр насны хүүхдүүд хичээллэх зориулалттай чийрэгжүүлэх талбай, Дугуйн зам, Гүйлтийн зам, Тамхины цэг, Био жорлон</li> <li>- Тохижилтын хэмжээнд 45ш автомашины зогсоол /Авто зам дагуух 30ш, тусдаа 17ш зогсоолоос автобусны зогсоол 1ш, ХБИ-ий зогсоол 2ш/</li> <li>- Дугуйн зогсоол /бш дугуй зогсох/, Саад саравч бүхий талбай, Нийтийн цуглах талбай, Явган зам талбай /ХБИ-ий хөтөч хавтан бүхий/, Сэндвич харуулын байр</li> </ul>
11		<b>C</b>	<b>1</b>	СХД-ийн 8-р хорооны 50 айлын орон сууцны барилгын урд талбайн бичил тохижилт болон СХД-ийн 9 дүгээр хороонд 3x3 сагсан бөмбөгийн талбайн тохижилт	<ul style="list-style-type: none"> <li>- 50-айлын урд талбайн тохижилт: Уг талбайд явган хүний зам 246 м<sup>2</sup>, саравч 1 ширхэг, тоглоомын талбай /6 сар-4 нас/ 87 м<sup>2</sup>, усан оргилуур 1ш, ногоон байгууламж 398 м<sup>2</sup> байхаар тус тус төлөвлөв. Ногоон байгууламж 398кв.м буюу нийт тохижилтын талбайн 54.2% эзлэхээр төлөвлөв.</li> <li>- Сагсны талбай: Уг талбай нь “3x3” төрлийн спортын талбай бөгөөд үндсэн тоглолтын талбай нь 13.9x17.9м хэмжээтэй байна. Хашаан дотроо 1.5м өргөнтэй явган хүний зам, 2 ширхэг сандал, 1ширхэг хогны сав байна. Хашааны өндөр 3.5м төмөр сараалжин. Төв замаас сагсны талбай руу холбогдох явган замтай.</li> </ul>
12			<b>2</b>	СХД-ийн 10-р хороонд бичил тохижилтын ажил	<ul style="list-style-type: none"> <li>- Уг талбай нь хүүхэд залуучуудад зориулсан жижиг хэмжээний экстрим талбайтай, хаданд авиралтын ханатай, 2 саравч, 3 сандал, 1 хогны сав, 1.5м өргөнтэй явган зам, явган зам дагуух ногоон байгууламж хэсэгтэй. Нийт талбайн 47.31% буюу 231.32м<sup>2</sup>ногоон байгууламж, 9.98% буюу 43.93м<sup>2</sup> явган зам, 40.68% буюу</li> </ul>

**ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

				194.02м2 экстрем талбай, 2.18% буюу 10.69м2 хаданд авиралтын хана байна.
13		3	СХД-ийн 8-р хороо, нийслэлийн 261 дүгээр цэцэрлэгийн гадна нэмэлт авто зогсоолын ажил”	- 261-р цэцэрлэгийн хажуугийн авто зам дагуух газар 21 машины зогсоол төлөвлөсөн. 2 зогсоол нь тэргэнцэртэй иргэний авто машины зогсоол байна. Нийт талбайн 50.95% буюу 981.13м2 авто зогсоол, 48.56% буюу 935.26м2 ногоон байгууламж, 0.49% буюу 73.81м2 явган зам талбай байна. Авто зогсоол нь байгалийн шигтгэмэл чулуу байна.
14		4	СХД-ийн 8-р хороо, бизнес инкубатор төвийн гадна нэмэлт авто зогсоолын ажил	- Бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төвийн хажууд 13 машины зогсоол төлөвлөсөн. 1 зогсоол нь тэргэнцэртэй иргэний авто машины зогсоол байна. Авто зогсоол нь байгалийн шигтгэмэл чулуу байна.
15		5	СХД-ийн 8-р хороо, Баянхошуу бизнес инкубатор төв болон нийслэлийн 261 дүгээр цэцэрлэгийн барилгын гадна фасадны засварын ажил	- Бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төвийн хажууд 13 машины зогсоол төлөвлөсөн. 1 зогсоол нь тэргэнцэртэй иргэний авто машины зогсоол байна. Авто зогсоол нь байгалийн шигтгэмэл чулуу байна.
16		<b>D</b>	Сэлбэ дэд төв дэх нийтийн зориулалттай ногоон байгууламж ба гадна талбайн тохижилтын ажлууд	- Багц 1- Сүхбаатар дүүргийн 14-р хороо, 35-р сургуулийн арын тохижилт: Нийт 1266м2 талбайтай, явган зам 390.72м2, спорт талбай 420м2, дасгалын талбай 152.27м2, саравч 3ш, 6-4 насны тоглоомын талбай 147.73м2, 5-12 насны хүүхдийн тоглоомын талбай 152.27м2, ногоон байгууламжийн талбай 625.15м2 - Багц 2 - Сүхбаатар дүүргийн 14-р хороо, 50 айлын баруун талд 3х3 сагсан бөмбөгийн талбай: Нийт талбай 800м2 байгууламж ба гадна талбайн тохижилтын ажил - 50 айлын орон сууцны зүүн хойд талд 0.025 га талбайд “3х3” төрлийн сагсан бөмбөгийн талбайн ажил
17	<b>SC</b>	<b>A</b>	Дэд төвийн байршлын талбайн цэвэрлэгээний ажил (1-р шат ,2-р шат)	- 160 нэгж талбар Баянхошуу, Дамба, Толгойт - Дууссан
18		<b>B</b>		
19	<b>TFP</b>	<b>TFP</b>	ТДТ-ийн үерийн усны хамгаалалтын суваг (1-р хэсэг)	- ТДТ-ийн үерийн хамгаалалт, ус зайлуулах - Үерийн усны хамгаалалтын суваг - Тунгаах байгууламж 2ш - Далд хоолой 2 байрлалд - Одоо байгаа далд хоолойг өргөсгөх 1 байрлалд - Автомашин болон явган хүний гарц 2 байрлалд - Дууссан
20		<b>A</b>	ТДТ-ийн үерийн усны хамгаалалтын суваг (2-р хэсэг)	- ТДТ-д (Баруун наран) үерийн хамгаалалт, ус зайлуулах хоолой - Үерийн усны хамгаалалтын суваг - Автомашин болон явган хүний гарц 5 байрлалд далд хоолой



**ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

21	<b>SHTSC</b>	<b>A</b>	Толгойтын ус, бохир ус, дулааны хоёрдогч холболт (Цэргийн хотхон)	- Ф530х8мм-ийн голчтой 1.3 км дулааны шугамын угсралтын ажил
22		<b>B</b>	Баянхошуу дэд төв(Оргил)-ийн цэвэр, бохир ус, халуун ус, дулаан түгээх шугам сүлжээний нийлүүлэлт, суурилуулалт	- Ариутгах татуургын шугам - 3км Гадна цэвэр усны шугам - 1,6км Дулаан хангамжийн шугам - 2км УДДТ-2ш
23		<b>C</b>	Дэд төвүүдийн бохир ус, дулааны хоёрдогч холболт	- Ариутгах татуургын шугам – 1.5км - Дулаан хангамжийн шугам – 1 км
24		<b>SHTSC</b>	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил	- Хийн халаалтын зуух суурилуулах ажил -9ш сургуульд нөөц цахилгаан үүсгэвэр суурилуулах ажил – 4 сургууль Ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажил – 5ш сургууль Бохир усны саармагжуулах төхөөрөмж суурилуулах ажил – 1ш сургууль - Дууссан
25	<b>TBC</b>	ТДТ сургалтын төв	- Тэнхлэгээрээ 50.0 х 33.0 м хэмжээтэй, хагас нум хэлбэртэй болон тэгш өнцөгтийн блокоос бүрдсэн 2 давхар, 2081 м2 талбай	
26	<b>PHC</b>	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төв	- СХД-ийн 34-р хороонд байрлах 15 ортой эмнэлэг - Барилгын нийт талбай - 4103.11м2 - Зоорийн давхартай, 3 давхар барилга - 25 ил автомашины зогсоол - Ногоон байгууламж-1627.2м2	
27	<b>TSC</b>	ТДТ-ийн бага сургууль. 320суудалтай, Ерөнхий боловсролын дунд сургууль	- Буулгалтын ажил 1958 онд ашиглалтад орсон дан давхар 386.5м2 хичээлийн байр буулгах. - Гадна тохижилтын ажил нийт 5820м2 талбайд автозам, явган зам талбай, эргийн бэхэлгээ, дугуйн зам, дугуйн зогсоол, сүүдрэвч, гэрэлтүүлэг, бялдаржуулах талбай, тавцант гулгуурын талбай, авто зогсоол, ногоон байгууламжаас бүрдэнэ. - Зоорийн давхартай, 3 давхар 640 хүүхдийн сургуулийн барилга. Нийт талбай 4704.6м2 гадна инженерийн шугам сүлжээний хамт	

**1.2. Төслүүдийн товч танилцуулга, хэрэгжилтийн байдал**

Толгойт дэд төвд ус, дулаан хангамж, ариутгах татуурга, цахилгаан холбоо, авто зам зэрэг дэд бүтэц, бизнес инкубатор, эрүүл мэндийн төв, сургууль зэрэг нийгмийн үйлчилгээний барилга байгууламж барих, өргөтгөх, тохижилт хийх, ашиглалтанд оруулах нийт 27 ажил хамаарч байгаагаас 2021-2022 онд 4 ажлыг хийж дуусгасан, 2024 онд 7 ажлыг хэрэгжүүлж эхэлснээс 1 нь хэрэгжиж дууссан бол үлдсэн 6 ажил

**ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2025 онд үргэлжлэх төлөвлөгөөтэй байна. Харин үлдсэн 16 ажлын гүйцэтгэгч тодорхойгүй, гэрээ хийгдээгүйн улмаас 2024 оны 10 сарын 20-ны байдлаар барилга угсралтын ажил хийгдэж эхлээгүй байна.

*Хүснэгт 2. Барилга, угсралтын ажлын хэрэгжилт.*

№	Гэрээний дугаар	Гэрээний нэр	Байршил	Хэрэгжилт	Гүйцэтгэгч байгууллага
1	TBC	Толгойтын дэд төв сургалтын төв	СХД-ийн 1р хороо	82%	“Мандалтконстракшн” ХХК болон “Алтайн бумбат Өргөө” ХХК-иудын түншлэл
2	TRDH11C	Толгойт дэд төвийн насосны станц болон шугам сүлжээ	СХД-ийн 1, 34 хороо	66.72%	И ЖИ ӨҮ ХХК болон НАБСАН ХХК-иудын түншлэл
3	TSC	Толгойт дэд төвийн бага сургууль, 320 суудалтай, Ерөнхий боловсролын дунд сургууль	СХД-ийн -р хороо	29%	“Уайт Феникс” ХХК
4	SHTSC-A	Толгойтын ус, брцохир ус, дулааны хоёрдогч холболт (цэргийн хотхон)	СХД-ийн 1, 2, 20р хороо	45%	“Модернхас” ХХК, “Энерготех сервис” ХХК-иудын түншлэл
5	SHTSC-B	Баянхошуу дэд төв (Оргил)-ийн цэвэр, бохир ус, халуун ус, дулаан түгээх шугам сүлжээний нийлүүлэлт, суурьлуулалт	СХД-ийн 23р хороо	14%	Набсан ХХК
6	SHTSC-C	Дэд төвүүдийн бохир ус, дулааны хоёрдогч холболт	СХД-ийн 13, 14, 15р хороо	100%	“Ус суьгийн удирдах газар” ОНӨААТҮГ
7	TFP-A	Толгойт дэд төвийн үерийн усны хамгаалалтын суваг (2-р хэсэг)	СХД-ийн 1, 2, 3, 4, 20р хороо	16%	“Монгол менежмент төв” ХХК, болон “Улаанбаатар менежмент” ХХК-иудын түншлэл

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 2.1 ТВС-Толгойт дэд төв сургалтын төв

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт-ТВС

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Төл/зардал, төг	Гүй/зардал, төг
	1	2	3	4	5
<b>Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>					
1	Газар шорооны ажилд 0.23 га талбайн газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүсэх	Сургалтын төвийн эдэлбэр газрын 10%-аас доошгүй хэсэгт гадна орчны тохижилтын ажлууд хийж, мод зүлэг тарьж, ногоон байгууламж үүсгэх	Барилгын ажил дууссаны дараа зураг төсөл төлөвлөлтийн дагуу нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэнэ.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	-
2	Газар шорооны ажлаас 3329м <sup>3</sup> хаягдал шороон материал үүсэх	Барилгын суурь ухах, гадна зам талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ зэрэг ажлуудаас үүсэх 3329 м <sup>3</sup> хэмжээтэй хаягдал шороон материалыг Цагаан давааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг СХД дүүргийн хот тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө.	“Мандалт констракшн” ХХК нь жил бүрийн БОМТ-нд тусгасны дагуу Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ТУН-ээр хянуулж, хэрэгжүүлэн ажиллаж ирсэн. Хог хаягдлын гэрээг СХД-ийн тохижилт үйлчилгээний газартай байгуулан ажиллалаа. Хог хаягдлын гэрээг хавсралт III харах.	Барилгын ажлын төсөвт багтсан	-
3		Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.			
4	Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орох	Газар шорооны ажлаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох	Барилгын газар шорооны ажлаас гарсан хаягдал чулуулгыг суурийн нөхөн дүүргэлтэнд дахин ашигласан ба илүүдэл хаягдал шороог Цагаандавааны хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулах ажлыг зохион байгуулж ажилласан.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	-
5		Хаягдал шороон материалын овоолгыг их хэмжээгээр хуримтлуулахгүйгээр тухай бүрд нь ачин зайлуулж байх	Газар шорооны ажил явагдсан талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж ажиллалаа.		

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ					
6	Газар шорооны ажил, талбайн тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас тоосжилт үүсэж агаар орчныг бохирдуулах	Хуурай өдрүүдэд газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд м2 талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх	<p>Барилгын ажлын үед тоос дарах усалгааг 2 өдөрт 1 удаа, тоосжилт ихтэй үед өдөрт 2-аас доошгүй тоос дарах усалгааг хийсэн.</p> 	816000	800 000
7		Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох	Төслийн үйл ажиллагааны үед хүчтэй салхи шуургатай өдрөөс шалтгаалан түр зогсолт хийсэн нөхцөл байдал үүссэнгүй. Харин ачиж буулгах үед үүссэн тоосжилтыг бууруулах арга хэмжээ болох усалгааг тогтмол хийж ажилласан.	Барилгын ажлын төсөвт багтсан	-
8		Хүчтэй салхи шуургатай үед хөрсний овоолгоос тоосжилт үүсэхээс сэргийлж усалгаа хийх	Усалгааг 2 өдөрт 1 удаа, тоосжилт ихтэй үед өдөрт 2-аас доошгүй тоос дарах усалгааг хийсэн.		
9		Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Төслийн үйл ажиллагааны тээвэрлэлтийн явцад хийгдсэн. Ачааны машины тэвшийг хэт дүүргэлгүй, 60 см орчим сул үлдээж, бүтээлэгтэй тээвэр хийх ажлыг зохион байгуулж ажилласан. Хяналтыг ХАБЭА-н инженер болон талбайн инженер тухай бүрт нь хариуцан ажиллалаа.		

ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

10		Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх	Барилгын ажилд ашиглагдаж буй автомашин механизмын техникийн бүрэн бүтэн байдлыг хянах тойрох үзлэгийг тогтмол зохион байгуулж ажилласан.		
11	Барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал, бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах	Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх	Барилга угсралтын ажилд байнга хэрэглэгдэж буй авто тээврийн хэрэгслийг улсын үзлэгт хамруулсан ба оношилгоонд тэнцсэн буюу шаардлага хангасан машин, техник ашиглаж байна.	300000	300 000
12		Ажлын талбайд тээврийн хэрэгслийг сул зогсолтын үед унтрааж байх, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, талбайн инженер болон ХАБЭА-ийн инженер сануулж ажиллах	Төсөл хэрэгжиж буй хугацаанд ажилчдад ХАБЭА-ний дүрэм, анхан шатны болон давтан зааварчилгааны сургалтанд хамруулж ажилласан. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр бүрэн хангаж ажилласан. Мөн барилгын ажил явагдаж буй талбайг хашаажуулан, холбогдох ХАБЭА-н тэмдэг тэмдэглэгээг байршуулан ажиллалаа.		
13		Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах	ОХШХ-ийн дагуу БОХЗТЛабораториор хэмжилтийг хийлгүүлж ажиллалаа. Хэмжилтээс харахад ЗДХ-ээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.		
14		Барилгын ажлын үед цемент, элс зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд хийсэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй	Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх		
15	Дулааны эх үүсвэр гаргах буюу хаягдал материалыг устгах зорилгоор шатамхай материалыг ил талбайд шатаахыг хориглоно	Хог хаягдлын тухай хууль болон төслийн талбайд хэрэгжүүлж буй хог хаягдлын менежмент журмын дагуу төслийн талбайд ил задгай хог шатааж устгахыг хориглож ажилласан.			
<b>Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>					
16	Газар шорооны ажил, барилга угсралтын 17ажил, барилгын материал тээвэрлэх,	Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношилгоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох	Барилган ажилд ашиглагдаж буй автомашин механизмын техникийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах, төслийн талбайд дуут дохио ашиглахыг хориглосон. Жолооч нарт сургалтаар орсон болно.	Барилгын ажлын төсөвт багтсан	-

ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

17	ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүсэх	Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх	Барилгын ажил 1 ээлжээр буй 09:00-18:00 цагийн хооронд явагдсан.		
18		Машины кабинд болон түүний ойр орчимд ажиллах буй ажилчид дуу чимээнээс хамгаалах чихэвч зүүж байх, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл зэргийг тогтмол бүрэн өмсөж хэрэглэх	төслийн хугацаанд компани бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг бүрэн өмсөж хэвшүүлэх ажлыг төслийн талбайд ХАБЭА-н инженер хяналт тавьж ажиллалаа.		
19		Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих	Барилгын ажлын үед оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байхыг зорьж аль болох бага дуу чимээ гаргах, дуут дохио ашиглахгүй байхаар зохион байгуулж ажиллалаа. .	ОХШХ-т тусган оруулсан	-
20	Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж, зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	СХД-ийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж, түүнд хаягдал шороон материал, ахуйн ба барилгын хог хаягдлыг зайлуулах цэг ба тээвэрлэх автомашины улсын дугаарыг тодорхой зааж өгөх	“Мандалт констракшн” ХХК нь СХД-ийн ОНӨААТҮГ-тай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллаж байна. Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж ажиллалаа. Үүнд: - Хог хаягдлын түр цэгийг байгуулан хашаажуулж, тэмдэгжүүлэх ажлыг хийсэн. - Төслийн талбайд хогийн савнуудыг байршуулж өгсөн - Ахуйн хог хаягдлыг зайлуулах ажлыг Хог хаягдлын гэрээний дагуу 14 хоногт 1 удаа хийж ажиллалаа.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	-
21		Барилгын ажил явагдаж буй газруудад хогийн хаягдлын цэг тогтоож, зориулалтын хогийн сав байрлуулах	- Барилгын хог хаягдлыг тухай бүрт Цагаандавааны хогийн цэгт көөвөрлөх ажлыг зохион байгуулсан. - Хог хаягдлын тухай хууль болон хог хаягдлын журмын дагуу хог хаягдлыг ил задгай хаяхгүй, шатааж устгахгүй байхыг хориглосон.		
22		Барилгын түр кемп тус бүрд хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх	- Төслийн талбайд хөрсөнд бохирдол үүсгэхээс сэргийлж зориулалтын соруулдаг нүхэн эорлон буюу цооногийг байршуулсан. 7 хоног тутам ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх ажлыг зохион байгуулан ажиллалаа.		
23		Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох	- “Талбайн журам”-нд ажил тарахын өмнөх 10 минутыг орчны цэвэрлэгээ тогтмол хийж байхаар заасан тул бүх ажилчид өдөр бүр орчны цэвэрлээ хийх ажлыг зохион байгуулж ажиллалаа.		
24		Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих			
25		Барилгын түр кемпүүдээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах			
26		Барилгын ажил дууссаны дараа хог хаягдлыг цуглуулж зайлуулах, талбайн цэвэрлэгээг бүрэн гүйцэд хийж хяналтын инженерт хүлээлгэн өгөх			

Гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ					
27	Их хэмжээний хур бороо орсны улмаас барилгын ажил явагдаж буй зам, талбай үерт автаж, машин техник эвдэрч гэмтэх, хүн осолдох	Онцгой байдлын төлөвлөгөө боловсруулж ажиллах, түүнд үерийн эрсдэлээс хамгаалах зохих арга хэмжээнүүдийг тусгаж өгөх	Гамшгаас хамгаалах Онцгой байдлын төлөвлөгөө боловсруулж, ХХАА-ны мэргэжилтэн хяналт тавин ажилласан.	Барилгын ажлын төсөвт багтсан	-
28	Барилгын түр кемпүүд, бүх инженерийн байгууламжууд нь үерээс хамгаалах байгууламжтай байх (үерээс хамгаалах далан, шуудуу зэрэг)	Барилгын түр кемпүүд, бүх инженерийн байгууламжууд нь үерээс хамгаалах байгууламжтай байх (үерээс хамгаалах далан, шуудуу зэрэг)	Бороо, үерийн үед барилгын талбайн гадаргуу, овоолго, бусад ил гарсан хэсэг усаар угаагдаж элэгдэх процессыг тооцоолон ажилласан.		
29	Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчих байдлаар гадаргын болон газрын доорх усны бохирдол үүсгэх	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх	Түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС-д хийж гүйцэтгэсэн	Барилгын ажлын төсөвт багтсан	-
		Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх	Тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлж, ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр тойрох үзлэгийг хийж ажиллалаа.		
30	Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах	Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах	Шатах тослох материал асгарч, хөрс бохирдохоос сэргийлэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан. Төслийн хугацаанд асгаралт үүсээгүй.	Барилгын ажлын төсөвт багтсан	-
31	Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус ашиглалтын гэрээ байгуулж ажиллах, Ундны усыг шаардлага хангасан ус хангамжийн эх үүсвэрээс авч байх	Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус ашиглалтын гэрээ байгуулж ажиллах, Ундны усыг шаардлага хангасан ус хангамжийн эх үүсвэрээс авч байх	Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажилласан. Ахуйн зориулалтаар ашиглах усыг ойролцоох хугацаас хангаж ажилласан тул, ус ашиглах гэрээ хийх шаардлагагүй гэж үзсэн.		
32	Барилгын болон ахуйн зориулалтаар багавтар хэмжээний ус ашиглах	Талбайн ажил эхлэхээс өмнө зам талбайн усалгаанд ашиглах тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгах, ус дамжуулах хоолой, крант, усны насосны ажиллагаа зэргийг тогтмол шалгаж усны алдагдал үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах.	Төслийн хугацаанд ахуйн болон тоосжилт дарах усалгааны усыг зөөврөөр ашигласан. Үйл ажиллагааны хугацаанд усыг зориулалтын дагуу ариг гамтай ашиглаж ажилласан. Ундны усыг 20л баллонтой усаар хангаж ажилласан.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	-
33	Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах	Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах	Ахуйн зориулалтаар ашиглаж буй худгийн усанд шинжилгээ хийлгүүлж ажилласан. Шинжилгээний дүнгээс харахад ЗДХ-ээс хэбэрсэн үзүүлэлт байхгүй байна.		
34	Шингэн хаягдал, 00-д хуримтлагдсан ялгадас зэрэг нь хөрсөнд нэвчиж газрын доорх усны	Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх	Түр кемпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж ариутгах ажлыг зохион байгуулж ажиллалаа.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	-
35	Нүхэн жорлонгийн бохир усыг соруулах гэрээг мэргэжлийн байгууллагатай байгуулах, бохир ус	Нүхэн жорлонгийн бохир усыг соруулах гэрээг мэргэжлийн байгууллагатай байгуулах, бохир ус	Нүхэн жорлонгийн бохирыг соруулах нөхцөл байдал үүсээгүй. Соруулах шаардлага үүсвэл мэргэжлийн		

**ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

	найрлага, чанарт нөлөөлж болзошгүй.	жорлонгийн нүхний 70%-д хүрэх бүрт соруулж байх	байгууллагаар соруулах ажлыг зохион байгуулж ажиллах болно.		
		Барилгын түр кемпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлорамин цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх	Барилгын түр кемпийн бие засах газарт ариутгал халдваргүйжүүлэлтийг 7 хоногт 1 удаа тогтмол хийж ажилласан.		
<b>Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>					
36	Машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрс суларч доройтох, хөрсний элэгдэл үүсэж болзошгүй	Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах	Тээвэрлэлт хийж буй хүнд даацын машин механизмуудыг тогтсон нэг маршрутаар явах зааварчилгаа өгч, тогтмол хяналтыг тавьж ажилласан.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан.	-
37		Барилгын ажил дуусах үед хөрс суларч доройтон, хөрсний элэгдэл үүссэн газруудад нөхөн сэргээлт, орчны тохижилт хийх			
38	Газар шорооны ажлын улмаас 0.23 га талбайн хөрс хуулагдах ба шимт хөрсний овоолгыг стандартын дагуу тусад нь үүсгэж хадгалаагүй нөхцөлд хөрсний чанар алдагдаж болзошгүй	Бохир хөрсийг хусаж зайлуулах, талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ хийх ажилд өртөж эвдэрсэн 0.09 га талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн сэргээлт, тохижилтын ажлууд хийх	Барилгын ажил дуусахад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөлтийн дагуу хийж гүйцэтгэнэ.		
		Газар шорооны ажлын үед бохирдсон хөрс ба шимт хөрсний овоолгуудыг тусад нь үүсгэж стандартын дагуу хадгалах ба барилгын ажил дуусах үед нөхөн сэргээлтэд ашиглах			
39	Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй.	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх	Түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС-д хийж гүйцэтгэсэн. Төслийн талбайд 4 удаагийн хяналтаар ажиллахад хөрсөнд тос маслын асгаралт үүссэн тохиолдол бүртгэгдээгүй.	500'000	450 000
40		Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх			
41		Эдэлбэр газрын дотор тээврийн хэрэгсэл түр зогсоох үед тусгайлан заасан тэмдэг тэмдэглэгээ бүхий автомашины зогсоол байгуулж, тэндээ байрлуулж байх			
42		Эдэлбэр газарт тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээг тусгайлан бэлтгэсэн, хөрс			



**ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

		бохирдохоос хамгаалсан зориулалтын талбай бэлтгэж, гүйцэтгэж байх	Зориулалтын засварын газраар гэрээгээр машин техникийн засвар үйлчилгээ хийлгүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.		
43	Хог хаягдал, кемпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдол зэргээс үүдэлтэй хөрсний бохирдол үүсэж болзошгүй.	Барилгын ба ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	“Мандалт констракшн” ХХК нь СХД-ийн ОНӨААТҮГ-тай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллаж байна. Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж ажиллалаа. Үүнд: - Хог хаягдлын түр цэгийг байгуулан хашаажуулж, тэмдэгжүүлэх ажлыг хийсэн. - Төслийн талбайд хогийн савнуудыг байршуулж өгсөн - Ахуйн хог хаягдлыг зайлуулах ажлыг Хог хаягдлын гэрээний дагуу 14 хоногт 1 удаа хийж ажиллалаа. - Барилгын хог хаягдлыг тухай бүрт Цагаандавааны хогийн цэгт көөвөрлөх ажлыг зохион байгуулсан. - Хог хаягдлын тухай хууль болон хог хаягдлын журмын дагуу хог хаягдлыг ил задгай хаяхгүй, шатааж устгахгүй байхыг хориглосон. - Төслийн талбайд хөрсөнд бохирдол үүсгэхээс сэргийлж зориулалтын соруулдаг нүхэн зорлон буюу цооногийг байршуулсан. 7 хоног тутам ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх ажлыг зохион байгуулан ажиллалаа. - “Талбайн журам”-нд ажил тарахын өмнөх 10 минутыг орчны цэвэрлэгээ тогтмол хийж байхаар заасан тул бүх ажилчид өдөр бүр орчны цэвэрлээ хийх ажлыг зохион байгуулж ажиллалаа.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	-
44		Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох			
45		Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх			
46		Барилгын түр кемпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлорамин цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх			
<b>Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>					
47	Газар шорооны ажлын явцад газрын хөрсөнд нуугдмал байсан археологи, палеонтологийн	Санамсаргүй олдвор илэрсэн цэгт барилгын үйл ажиллагааг нэн даруй зогсоох	БОННУ-ний багийн төслийн талбайд хийгдсэн судалгаагаар Толгойт дэд төвийн хил хязгаарт дотор ямарваа нэгэн түүх соёлын өв дурсгалт газрууд байхгүй болох нь тогтоогдсон тул энэхүү төсөлд түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний	Барилгын ажлын төсөвт багтсан	-
48		Санамсаргүй олдвор илэрсэн тухай дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх			

**ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

49	санамсаргүй олдвор, илэрч болзошгүй	Археологийн хүрээлэнгийн мэргэжлийн баг ажиллуулж шаардлагатай судалгаа шинжилгээ хийлгэх, шаардлагатай бол авран хамгаалах малтлага хийлгэх	төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх шаардлага байхгүй гэж үзсэн		
<b>Нийгэм, олон нийтэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>					
50	Барилга угсралт, газар шорооны ажлуудаас тоосжилт үүсэх	Газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд 1 м <sup>2</sup> талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх	Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлангаас харах	Энэхүү төлөвлөгөөний агаарын чанарын хэсэгт төсөвлөсөн төсвийн дагуу	-
51		Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс газар шорооны ажлыг түр зогсоох			
52		Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх			
53	Барилгын материал тээвэрлэх, газар шорооны ажлуудаас дуу чимээ үүсэж ойр орчмын оршин суугчдын тав тухыг алдагдуулах	Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх	Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлангаас харах	Барилгын ажлын төсөвт багтсан	-
54		Шаардлагатай тохиолдолд дуу чимээ тусгаарлах зөөврийн хана ашиглах			
55		Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх			
56	Барилга угсралтын үйл ажиллагааны үед өндрөөс юм унаж хүн гэмтэж болзошгүй	Барилга угсралтын үед хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд хатуу сахиж ажиллах	Төслийн үйл ажиллагааны туршид ХААБ-ын дүрэм журмыг чандлан сахиж мөрдөж ажиллалаа. Үйл ажиллагааны хугацаанд аваарь осол бүртгэгдээгүй ажилласан байна.	Барилгын ажлын төсөвт багтсан	-
57		Баригдаж буй барилгыг тойруулан хамгаалалтын хашлага татаж явган зорчигч ойртохоос сэргийлэх	Хамгаалтын хашлага, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байршуулан ажилласан.		
58		Шаардлагатай тохиолдолд баригдаж буй барилгын хажуугаар явган зорчигч нэвтрэх хамгаалалтын саравч бүхий гарцууд гаргаж өгөх	Төслийн үйл ажиллагаа нь сулгалтын төвийн хашаан дотор явагдсан учир явган зорчигч нэвтрэх хамгаалалтын саравч бүхий гарц гаргах шаардлага байгаагүй.		
		Анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Хамгаалтын хашлага, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байршуулан ажилласан.		
59	Цемент, шохой, элс зэрэг нунтаг материал агаарт дэгдэж үзэгдэх орчныг хязгаарлаж болзошгүй	Зам барилгын болон барилгын ажилд хэрэглэгддэг цемент, элс, шохой зэрэг нунтаг материалыг битүү орчинд буюу тусгайлсан саванд хадгалах	Цемент, элс, шохой зэрэг нунтаг материалыг салхины нөлөө болон бороонд норгохгүй байхаар битүүмжлэлтэй агуулахад хадгалах ажлыг зохион байгуулсан.	Барилгын ажлын төсөвт багтсан	-

ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

60	Барилгын материал тээвэрлэх үйл ажиллагааны үед зам тээврийн осол аваар гарах буюу ус зөөж буй хүүхдүүд, явган зорчигчдын аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй	Хүнд даацын машины жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын давтан сургалтад хамруулах, гэр хорооллын суурьшлын бүс дунд үүсэж болзошгүй эрсдэл, осол аваарын талаар тайлбарлан таниулах	Хүнд даацын машины жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын хөдөлгөөний дүрмийг мөрдүүлж ажиллах, гэр хорооллын дундах хурдны хязгаарыг 10км/цаг байхаар зааж өгсөн. Үйл ажиллагааны хугацаанд гарсан үл ойлголцол, зөрчил байхгүй байна.	Барилгын ажлын төсөвт багтсан	-
61	Гэр хороолол дунд тээврийн машины хурдыг хязгаарлах дүрэм мөрдүүлэх			Нэмэлт зардал гарахгүй	-
62	Тээврийн жолооч нарт худаг, хүүхдийн сургууль, цэцэрлэг, явган хүний гарц, уулзвар зэрэг осол аваар гарах эрсдэл бүхий цэгүүд дээр 5 секунд зогсоод хөдлөх дүрэм мөрдүүлэх				
63	Кемпийн орчинд хог хаягдал, бохир усыг замбараагүй зайлуулснаас үүдэн орчны бохирдол, үнэр танар үүсгэх	Барилгын түр кемп бүрд дараах эрүүл ахуйн үндсэн шаардлагууд тавигдана. Үүнд:	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайланд тодорхой тусгасан.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	-
64		1.Хатуу хог хаягдлын менежмент. Хатуу хог хаягдлыг түр хадгалах зориулалтын цэг бий болгож, хашлага хамгаалалт хийж, тэмдэг тэмдэглэгээ байршуулах ба СХД-ийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг 7 хоногт 2 удаа ачуулж байх			
65		2. Шингэн хог хаягдлын менежмент. Кемпээс гарах бохир усыг битүү саванд түр хадгалж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх			
		3. Ажилчдын 00. Эрүүл ахуйн шаардлага хангасан 00-той байх, 00-н нүхэнд био-бэлдмэл ашиглаж халдваргүйжүүлэлт хийх, ойр орчмыг нь хлорамин шингэнээр тогтмол ариутгаж цэвэрлэх			
66	Кемпийн орчинд сахилга бат, хэв журмын зөрчил гаргаж оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	Барилгын ажилчдыг БОМТ, эрүүл ахуйн сургалтад хамруулж, зөрчлийн хуулийн холбогдох заалтуудыг сурталчлан таниулсан байх	ХАБ-ын анхан шатны болон давтан зааварчилгааны сургалтуудын агуулгад зөрчлийн тухай хууль, төслийн талбайд баримтлах дүрэм, согтууруулах ундааны хэрэглээ, оршин суугчдын тав тухыг алдагдуулахгүй байх зэрэг багтсан тул бүх ажилчдад сургалтаар орж, мөрдөн ажиллалаа.	Барилгын ажлын төсөвт багтсан	-
67		Кемпийн орчинд мөрдөх дотоод журамд сахилга батын асуудлыг нарийвчлан тусгаж өгөх ба үүнд согтууруулах ундаа хэрэглэх, ойр орчмын оршин суугчидтай асуудал зөрчил үүсгэх зэргийг хатуу хориглох			
68	Гадна зам талбайн тохижилтын ажилд ашиглагдах хүнд даацын	Замын индүүдэгч, бетон зуурмаг, асфальт тээвэрлэгч, дэвсгэгч зэрэг том оврын машин тэрэгний ажлын үед хяналтын дохиурчныг	Үйл ажиллагааны хугацаанд талбайн инженер болон ХАБЭА-н инженер тухай ажлаас хамаарч гарч болох	Барилгын ажлын төсөвт багтсан	-

**ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

	машин механизмууд осол аваар гаргаж болзошгүй	зайлшгүй ажиллуулах шаардлагатай ба том оврын машин тэрэг ухрах, эргэх маневруудыг зөвхөн хяналтын дохиурчны дохиогоор хийж гүйцэтгэх	эрсдлийг үнэлж шаардлагатай тохиолдолд дохиочин гаргах ажлыг тухай бүрт нь зохион байгуулж ирсэн.		
69	Өндөр хэмтэй асфальт болон бетон зуурмаг алдагдаж хүний гар хөл түлэгдэж гэмтэж болзошгүй	Бетон зуурмаг, асфальт материал тээвэрлэх, буулгах, хучилт хийх ажлуудыг нарийн чанд горимын дагуу тогтоосон талбайн хүрээнд гүйцэтгэж, санамсаргүй асгаралт үүсгэхээс сэргийлэх	Төслийн хугацаанд ямар нэгэн материалын санамсаргүй асгаралт бүртгэгдээгүй болно. Хэрэв үүссэн тохиолдолд тухай бүрт нь тохирсон арга хэмжээнүүдийг авч ажиллах болно.		
70		Зам барилгын ажлын талбарт ажиллаж буй ажилчид хамгаалалтын хувцас хэрэглэлтэй байх	Компани бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцасаар бүрэн хангаж ажилласан. ХАБЭА-н инженер ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг бүрэн өмсөж хэвшүүлэх болон хяналтыг тавьж ажилласан.		
<b>Төсөв</b>				<b>1 616 000</b>	<b>1 550 000</b>

Зураг 2. Хавсралт фото зургууд-ТВС

											
<p>Барилгын ажлын явц</p>											
											
<p>Тоос дарах усгааны сав</p>	<p>Талбайн цэвэрлэгээ хийсэн буй байдал</p>										
	 <table border="1" data-bbox="794 1473 1133 1550"> <tr> <td>захиалагч</td> <td>GADIP</td> </tr> <tr> <td>гүйцэтгэгч</td> <td>Мандалт констракшн ххк</td> </tr> <tr> <td>байршил</td> <td>Сургалтын төв</td> </tr> <tr> <td>ажилбар</td> <td>Гадна гэрэлтүүлгэ аслаа</td> </tr> <tr> <td>огноо</td> <td>2024.10.16</td> </tr> </table>	захиалагч	GADIP	гүйцэтгэгч	Мандалт констракшн ххк	байршил	Сургалтын төв	ажилбар	Гадна гэрэлтүүлгэ аслаа	огноо	2024.10.16
захиалагч	GADIP										
гүйцэтгэгч	Мандалт констракшн ххк										
байршил	Сургалтын төв										
ажилбар	Гадна гэрэлтүүлгэ аслаа										
огноо	2024.10.16										
<p>Талбайн цэвэрлэгээ хийж буй байдал</p>	<p>Сулгалтын талбайн гэрэлтүүлэг</p>										

2.2. TRDH11C-Толгойт дэд төвийн насосны станц болон усан шугам сүлжээ-2890м усан хангамжийн сүлжээ

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт-TRDH11C

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Төл/зардал, төг	Гүй/зардал, төг
	1	2	3	4	5
<b>Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>					
1	Газар шорооны ажлаас нийт 11.17 га талбайн газрын гадарга эвдрэлд өртөнө	Авто зам тавих ажилд өртөж эвдэрсэн 3.97 га талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн сэргээлт, тэгшилгээний ажлууд хийж, хэлбэршүүлэх, орчны тохижилт үүсгэх	Газар шорооны ажил дуусмагц төлөвлөлтийн дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж ажиллана.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	-
2	Газар шорооны ажлаас нийт 30,564 м3 хаягдал шороон материал үүснэ	Газар шорооны ажлаас үүсэх нийт 39,400.96 м <sup>3</sup> Үүсэх бөгөөд үүний 13,726.3 м <sup>3</sup> хэмжээтэй хаягдал шороон материалыг Цагаан давааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг Сонгинохайрхан дүүргийн хот тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө.	Хог хаягдлын гэрээг СХД-ийн тохижилт үйлчилгээний газартай байгуулан ажиллалаа. - Кэмпээс гарах ахуйн хог хаягдлыг гэрээний дагуу зайлуулах ажлыг зохион байгууллаа. - Газар чөлөөлөлт, газар шорооны ажлаас үүссэн хог хаягдлыг техникийн үзлэг оношилгоонд орсон өөрсдийн тээврийн хэрэгслээр Нарангийн хогийн цэгт тухай бүрт нь төлбөрийг төлж зайлуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа..		
3		Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.	ТУН-аас өгсөн үүрэг даалгаврын дагуу тухай бүрт мэдээллээр хангаж ажиллаж байна.	Барилгын ажлын төсөвт багтсан	-
4	Гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орно	Авто зам ба дулаан, цэвэр, бохир ус, дренажийн шугам хоолой тавих газар шорооны ажлуудаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох	Гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр төлөвлөн ажиллаж байна.		

5		Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрлаж байсан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	-
<b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>					
6		Авто зам ба дулаан, цэвэр, бохир ус, дренажийн шугам хоолой тавих газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд хуурай өдрүүдэд м <sup>2</sup> талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх	Энэ онд газар шорооны ажлын хэмжээ бага хийгдсэн учир тоосжилт харьцангуй бага үүссэн мөн хур бороо элбэг орсон тул усалгаа хийгдээгүй.	520645	-
7		Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох	Үйл ажиллагааны туршид хүчтэй салхи шуургатай мэдээлэл бүртгэгдээгүй тул түр зогсолт хийгдээгүй.		
8	Газар шорооны ажил, талбайн тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас 925.344 кг/жил хэмжээтэй тоосжилт үүсэж агаар орчныг бохирдуула	Хүчтэй салхи шуургатай үед хөрсний овоолгоос тоосжилт үүсэхээс сэргийлж усалгаа хийх	Энэ онд газар шорооны ажлын хэмжээ бага хийгдсэн учир тоосжилт харьцангуй бага үүссэн мөн хур бороо элбэг орсон тул усалгаа хийгдээгүй.		
9		Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучих бүтээлтэй тээвэрлэлт хийх ажлыг зохион байгуулж ажиллалаа.	Барилгын ажлын төсөвт багтсан	-
10	Зам барилга, барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал,	Зам барилга, барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх	Барилга угсралтын ажлын талбайд мөрдөх аюулгүй ажиллагааны журмыг гүйцэтгэх захирлаар батлуулан төслийн талбайд мөрдлөг болгон ажилладаг. Уг журамд барилгын талбайд нэвтрэх, ажлын цагийн хуваарь, ажил эхлэх, ажлын байрны үзлэг, тэмдэг тэмдэглэгээ,		



**ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

11	бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах	Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх	өндрийн ажил гүйцэтгэх, цахилгааны аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа, эмх цэгцтэй цэвэр орчин, өндрөөс эд зүйл унах аюулаас сэргийлэх, аюулыг мэдээлэх хуудас, хамгаалалтын бүс малгай хэрэглээгүй тохиолдолд авах арга хэмжээ, ажлыг зогсоох, барилгын талбайн дэг журам, ажил дуусах зэрэг зүйлүүдийг багтаасан болно. Иймд төслийн талбайд өөрийн болон гэрээт компаниудын машин техник хэрэгслүүд нэвтрэх эрхтэй ба тухай бүрт нь авто оношилгоо болон техникийн бүрэн бүтэн байдлын үзлэг оношилгоог тогтмол хийж төслийн талбайд нэвтрүүлдэг.		
12		Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах		ОХШХ-т тусган оруулсан	-
13	Цемент, элс зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд хийсэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй	Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх	Талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж ТУН тайлагнан ажилласан.	Барилгын ажлын төсөвт багтсан	-
14		Дулааны эх үүсвэр гаргах буюу хаягдал материалыг устгах зорилгоор шатамхай материалыг ил талбайд шатаахыг хориглоно	Хог хаягдлын тухай хууль болон хог хаягдлын журмын дагуу ил задгай хог хаях, шатаахыг төслийн талбайд бүрэн хориглосон. Хориглосон тухай тэмдэг тэмдэглэгээг төслийн талбайд байршуулан ажиллалаа.		
